

**ХӨГЖИНГҮЙ ОРНУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ  
ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл,  
И.Жаргалзаяабямба, О.Билгүүтэй, Б.Туул*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. УЛС ОРНУУДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1.КАНАД УЛС

2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

3.ЯПОН УЛС

4.НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Хөгжингүй орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг зохицуулах бодлого, хууль эрх зүйн орчин” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** Өндөр хөгжилтэй орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ зохицуулах чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаар судлах.

**Судалгааны хамрах хүрээ:** Энэ судалгаанд Канад, БНСУ, Япон, Нидерланд зэрэг хөгжингүй орнуудын туршлагыг авч үзлээ.

Судалгаа 2 бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) гаргасан “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгааны хүрээнд дэлхийн улс орнуудын хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бодлого, арга хэмжээний талаар товч тоймлон оруулав. Хоёрдугаар бүлэгт, судалгаанд авагдсан орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ зохицуулах чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаарх туршлагыг авч үзлээ.

**Судалгааны арга зүй:** Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ холбогдох мэдээллийг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалгад өгсөн асуултуудын хүрээнд мэдээллийг судлах, нэгтгэн дүгнэх, харьцуулах зэрэг арга зүйг ашиглав.

**Түлхүүр үг:** зах зээлийн үнийг зохицуулах, хөдөө аж ахуйн салбарын бодлого

**Keyword:** market price support policy, agricultural policy

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улс орнуудын хүнс, хөдөө аж ахуйн (ХАА) бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын бодлого нь харилцан адилгүй байдаг бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд ялгаатай байна.

Хөгжингүй орнуудын хувьд дотоодын үнийг дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр барих бодлого баримтлан дотоодын ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд дотоодын хүнсний бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дотоодын үнийг экспортын үнээс бага байлгах бодлого баримтлах нь түгээмэл байдаг.

Гэхдээ үнийн зохицуулалтын бодлого нь дотоодын хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх боловч дэлхийн хэмжээний хүнсний хомстолд хүргэх сөрөг нөлөөтэй ба үнийг өндөр түвшинд барьснаар дотоодын үйлвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулж, хэрэглэгчдэд нэмэлт дарамт болно гэж үздэг. Тиймээс энэхүү бодлогод шүүмжлэлтэй хандах болсон.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) гаргасан “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгааны тайланд тэмдэглэснээр тус байгууллагын гишүүн орнууд үнийн зохицуулалтын арга хэмжээгээ багасгах болсон. 2015 онд батлагдсан Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрмээр экспортыг дэмжсэн татаасыг хориглосноор ихэнх улс орнууд үнийн зохицуулалтын бодлогоосоо татгалзах болсон ба түүний оронд орлого дэмжих төсвийн татаасын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

**Судалгаанд авагдсан орнуудын хүнс, ХАА-н бүтээгдэхүүний үнийг зохицуулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаар тоймлон авч үзвэл:**

Судалгаанд авагдсан БНСУ, Канад, Япон, Нидерланд зэрэг орнуудын туршлагаас харахад орон болгоны хувьд төрөөс дэмжлэг үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүний төрөл болон тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн хэлбэр өөр өөр байна. Эдгээр орнуудад (бүгд хөгжингүй орнууд) татаас олгох, бага хүүтэй зээл олгох болон бусад хэлбэрээр дэмжих бодлого хэрэгжүүлж байна.

- БНСУ-ын хувьд дэмжлэг олгодог хүнсний гол бүтээгдэхүүн цагаан будаа бөгөөд Засгийн газар нь нийт үйлдвэрлэсэн будааны тодорхой хувийг (23-30%) худалдаж авдаг. Түүнээс гадна цагаан будааны тариалан эрхлэгчдэд талбайн төлбөр болон ургацын хомстлын төлбөрийг олгох, бага хүүтэй тусгай зээл олгох зэрэг дэмжлэгийг үзүүлж байна.
- Канадад Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 5 төрлийн бүтээгдэхүүнд (сүү, сүүн бүтээгдэхүүн; тахианы мах, махан бүтээгдэхүүн; цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн; өндөг; үржүүлгийн өндөг) төрөөс дэмжлэг үзүүлж байна. Эдгээр бүтээгдэхүүний борлуулалтын орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний татаасыг фермерүүдэд олгодог. Энэхүү дэмжлэгийн хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүнд олгох дэмжлэг хамгийн өндөр (борлуулалтын орлогын 34%) байна, түүний дараа шувууны мах, махан бүтээгдэхүүн (борлуулалтын орлогын ойролцоогоор 16%), өндөг (борлуулалтын орлогын ойролцоогоор 10%) ордог. Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг тухайн бүтээгдэхүүний Маркетингийн зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлдэг.
- Японд цагаан будаанд дэмжлэг үзүүлдэг бөгөөд орлогын даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Нидерландын Засгийн газрын хүнсний бодлого байгаль орчин болон амьтанд хор хөнөөлгүй, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдэнэ. Засгийн газар нь хөдөө аж ахуйг олон талаас хөгжүүлэх, тогтвортой газар тариалан, байгалийн бүс нутгийг нөхөн сэргээх, арчлах чиглэлээр бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж, санхүүжүүлдэг байна.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын тусгай дэмжлэг үзүүлдэг хүнс, ХАА-н бүтээгдэхүүний төрлүүд, дэмжлэгийн хэлбэр болон хууль эрх зүйн орчны талаарх тойм

	Дэмжлэгт хамрагдах бүтээгдэхүүн	Дэмжлэгийн хэлбэр	Хууль эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй стратеги, хөтөлбөрүүд
БНСУ	Цагаан будаа	Засгийн газар нөөц бүрдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нийт үйлдвэрлэсэн будааны 23-30%-ийг худалдаж авдаг. Цагаан будааны тариалан эрхлэгчдэд талбайн төлбөр болон ургацын хомстлын төлбөрийг олгодог. Тусгай хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй зээл олгож байна.	<u>Хууль</u> <b>Цагаан будааны орлогын нөхөн олговрын тухай хууль</b> (Rice Income Compensation Act) <b>Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүнийг тогтворжуулах тухай хуулийг хэрэгжүүлэх журам</b> (Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products) <u>Хөтөлбөр</u> <b>Нийтийн хүнсний үр тарианы нөөцийг хангах хөтөлбөрийн хүрээн дэх Засгийн газрын будаа худалдан авах хөтөлбөр</b> (Government Rice Purchase Program under the Public Food Grain Stockholding Program) <b>Засгийн газар болон Үндэсний хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны (NACF) цагаан будааны бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хөтөлбөрүүд</b> (Government and National Agricultural Cooperative Federation's (NACF's) Loan Programs to Rice Millers)
Канад	1.сүү, сүүн бүтээгдэхүүн; 2.тахианы мах, махан бүтээгдэхүүн; 3.цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн; 4.өндөг; 5.үржүүлгийн өндөг.	Төрөөс фермерүүдэд сүү, сүүн бүтээгдэхүүнд борлуулалтын орлогын 34%, шувууны мах, махан бүтээгдэхүүнд ойролцоогоор 16%, өндөгний хувьд ойролцоогоор 10%-тай тэнцэх татаас олгож байна.	<b>Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хууль</b> (Farm Products Agencies Act) <b>Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль</b> (Canadian Dairy Commission Act)
Нидерланд	Тогтвортой үйлдвэрлэл 1.ХАА бүтээгдэхүүн (сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, амьтны гаралтай бүтээгдэхүүн) 2.Газар тариалан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 3.уураг 4.загасны аж ахуй, загас агнуур	Засгийн газар сүү, сүүн бүтээгдэхүүн, мах зэрэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ХАА эко системийг бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 60 сая евро 65,4 сая ам.доллар 2022 онд төсөвлөсөн байна. Энэ санхүүжилт нь инновацийн салбарыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилготой байна. Үндэсний өсөлтийн сан	<u>Хууль</u> <b>ЕХ-ны Хүнсний Ерөнхий хууль</b> (EU General Food Law) <b>Барааны тухай хууль</b> (Commodities Act) <b>Барааны тухай хуульд хүнсний аюулгүй байдлын тухай зохицуулалт</b> (Food safety regulations in the Commodities Act) <b>ЕХ-ны олон улсын хүнсний стандарт, дүрэм журам</b> (Codex Alimentarius) <b>Амьтан үржүүлгийн журам</b>

		(National Growth Fund) -г байгуулж, 2021-2025 онуудад эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хамгийн өндөр чадамжтай хоёр салбарт 20 тэрбум еврогийн хөрөнгө оруулалтыг зарцуулна.	(Animal Breeding Regulation) <b><u>Бодлого, хөтөлбөрүүд</u></b> <b>ЕХ-ны ХАА-н нэгдсэн бодлого</b> (EU Common Agricultural Policy (CAP)) <b>Баруун хойд Европ дахь амьтны гаралтай бүтээгдэхүүнийг тогтвортой хөгжүүлэх хөтөлбөр</b> (Advancing sustainable animal products in Northwest Europa. 2020) <b>Загасны аж ахуйн нийтлэг бодлого</b> (Common Fisheries Policy) <b>ХАА, байгаль, хүнсний чанарын яамны 2030 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөө</b> (Ministry of Agriculture, Nature and Food Quality of The Netherlands, Plan of action 2030)
Япон	Цагаан будаа	Цагаан будааны тариалангийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой орлогын даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Даатгалын хугацаанд орлого нь жишиг үзүүлэлтийнхээ 90 хувиас доогуур байвал тариаланчдад орлогын алдагдлын 90 хүртэлх хувийг нөхөн олгох боломжтой.	<b><u>Хууль</u></b> <b>Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах тухай хууль</b> (Law for Stabilization of Supply Demand and Price of Staple Food) <b>Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загас, загасан бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль</b> (Act on Facilitating the Export of Agricultural, Forestry, and Fishery Products and Food). <b>Японы хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль</b> (Japan Revises Agricultural Export Facilitation Act) <b><u>Стратеги төлөвлөгөө</u></b> <b>Япон Улсын хөдөө аж ахуйн экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө.</b>

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### НЭГ. УЛС ОРНУУДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Аливаа улсын эдийн засаг нь анхдагч буюу хөдөө аж ахуйн салбар, хоёрдогч буюу аж үйлдвэрийн салбар, гуравдагч буюу үйлчилгээний салбар гэсэн уламжлалт 3 хэсгээс бүрддэг. Хөдөө аж ахуйн (ХАА) салбар нь нөгөө 2 салбараа бодвол бүтээмж бага байдаг тул энэ салбарын ажил эрхлэлт, орлогыг дэмжих зорилгоор улс орнууд ХАА-г дэмжих бодлого авч хэрэгжүүлдэг. Улс орнуудын ХАА-г дэмжих бодлого нь үндсэн 3 зорилтыг хангахад чиглэж байна.

- Дотоодын хүнсний хүртээмж, аюулгүй байдлыг хангах;
- Фермерүүд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг дэмжих;

- Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх.


Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD-ЭЗХАХБ) 2022 оны 6-р сард гаргасан судалгааны тайланд тэмдэглэснээр<sup>134</sup> улс орнууд ХАА-н салбарыг дэмжихэд чиглэсэн ямар бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг талаар тоймлон авч үзье. ЭЗХАХБ нь улс орнуудын ХАА-г дэмжих бодлогыг хэмжихдээ TSE (Total Support Estimate) буюу Нийт дэмжлэгийн хэмжээ гэсэн үзүүлэлтийг тооцон гаргадаг. Энэ нь ХАА-г дэмжих бодлогын хүрээнд шууд болон шууд бусаар хуваарилагдаж буй хөрөнгийн тооцоолсон үзүүлэлт юм. TSE буюу Нийт дэмжлэгийн хэмжээ нь дор дурдсан 3 хэсгээс бүрдэнэ.

1. Үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг буюу Producer Support Estimate (PSE)
2. Салбарын ерөнхий дэмжлэг буюу General Services Support Estimate (GSSE)
3. Хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг буюу Consumer Support Estimate (CSE)

ХАА-н салбарыг дэмжихэд зарцуулж буй хөрөнгө нь дараах 2 аргаар хуваарилагдаж байна.

- Зах зээлийн зохицуулалт;
- Төсвийн хуваарилалт.

Зураг 1. ХАА-н салбарт үзүүлдэг дэмжлэгүүд



ХАА-н салбарыг дэмжих бодлогын хүрээнд хуваарилагдаж буй хөрөнгийн дийлэнх нь үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг байдаг. Үйлдвэрлэгчид үзүүлж буй дэмжлэг нь үнийн зохицуулалтын бодлогоор дамжуулан дотоодын үнийг өндөр түвшинд тогтоох, эсхүл төсвөөр дамжуулан үйлдвэрлэгч, фермерүүдэд олгож буй татаасаас бүрдэнэ.

ХАА-н салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, судалгаа шинжилгээнд зарцуулж буй хөрөнгө, улсын нөөц бүрдүүлэх, маркетингийн гэх мэт үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хөрөнгө нь Салбарын ерөнхий дэмжлэг болно. Энэ нь төсвийн санхүүжилтээс бүрдэнэ.

Хэрэглэгчид үзүүлж буй дэмжлэг нь хүнсний талон олгох, үнийн хяналт тогтоох гэх мэт хэрэглэгчийн ХАА, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний зардалд хөнгөлөлт үзүүлж буй арга хэмжээ юм.

<sup>134</sup> “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгаа нь ЭЗХАХБ-аас гаргадаг судалгаа бөгөөд өндөр хөгжилтэй 42 улс болон хөгжиж буй 12 улсыг хамарч хийгдсэн судалгаа юм. Эдгээр 54 улсын хөдөө аж ахуйн салбар нь дэлхийн хөдөө аж ахуйн салбарын нэмэгдсэн өртгийн 3/4-ийг бүрдүүлдэг.  
<https://www.oecd.org/publications/agricultural-policy-monitoring-and-evaluation-22217371.htm>

ЭЗХАХБ-ын судалгаагаар 2018-2020 оны хооронд улс орнууд жилд дунджаар 720 тэрбум ам.долларын дэмжлэгийг ХАА-н салбарт хуваарилжээ. Үүнээс үйлдвэрлэгчид олгох дэмжлэг нь жилд дунджаар 540 тэрбум ам.доллар буюу нийт ХАА-н салбарын дэмжлэгийн 75%-ийг бүрдүүлж байгаа бол Салбарын ерөнхий дэмжлэг нь 102 тэрбум ам.доллар буюу 14%-ийг, Хэрэглэгчид үзүүлж буй дэмжлэг нь 78 тэрбум ам.доллар буюу 11%-ийг бүрдүүлж байна.

### **Үнийн зохицуулалтын бодлого буюу Market Price Support Policy**

Үйлдвэрлэгчид дэмжлэг үзүүлэх бодлогыг голчлон үнийн зохицуулалт хийх замаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн талаас илүү хувийг бүрдүүлдэг.

Үнэ зохицуулах буюу Market Price Support бодлого нь хилийн үнэ болон дотоодын үнийн зөрүүг бий болгох замаар үйлдвэрлэгчид дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг бодлого юм. Ихэвчлэн өргөн хэрэглээний голлох хүнсний бүтээгдэхүүнд энэхүү бодлогыг хэрэгжүүлдэг.

Үнэ зохицуулах буюу Market Price Support бодлогын зорилго нь:

- Дотоодод хүнсний хүртээмжийг сайжруулах;
- Хүнс, ХАА-н компаниуд, фермерүүдийн орлогыг дэмжих;
- Хүнс, ХАА-н компаниуд, фермерүүдийг дампуурлаас сэргийлэх;
- Хүнс, ХАА-н салбарын ажил эрхлэлтийг дэмжихэд оршино.

Энэ бодлогын хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлдэг:

- Тарифын зохицуулалтын хүрээнд гаалийн татвар ногдуулах;
- Импорт, экспортын хэмжээ (квот) тогтоох;
- Үнийн доод (дээд) хэмжээг тогтоох;
- Татаас хэлбэрээр үнийн зөрүүг олгох замаар ХАА-н компани, фермерүүдийн алдагдлыг бууруулах, орлогыг дэмжих;
- Төр дэлхийн зах зээлийнхээс өндөр үнээр худалдан авалт хийх.

ЭЗХАХБ-ын судалгаагаар 2018-2020 онуудад улс орнуудын үнийн зохицуулалтын бодлогын хүрээнд үйлдвэрлэгчид үзүүлж буй дэмжлэг нь жилд дунджаар 272 тэрбум ам.доллар буюу ХАА-н салбарын дэмжлэгийн 38%-ийг, үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн 60%-ийг бүрдүүлж байна.

Үнэ зохицуулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлдэг хамгийн түгээмэл арга хэмжээ нь тарифын буюу импортын татвар ногдуулах, квот тогтоох арга байдаг. Жишээ нь, дэлхийн дунджаар ХАА-н бүтээгдэхүүний импортын татварын дундаж хэмжээ нь 7.8% (аж үйлдвэрийн бүтээгдэхүүний татвар 4.6%) байна. Дэлхийн худалдааны байгууллагын журмаар улс орнууд ХАА-н бүтээгдэхүүнд ногдох импортын татварын дундаж хэмжээг дунджаар 48.9% хүртэл нэмэгдүүлж (харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүний татварыг 27.1% хүртэл нэмэгдүүлж болно) болдог.

ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр үнийн зохицуулалтын нөлөө хамгийн өндөр байгаа улс нь Өмнөд Солонгос, Япон, Исланд, Норвег, Швейцар улсууд бөгөөд эдгээр улсын үнийн зохицуулалтын бодлогын нөлөө нь дунджаар ХАА-н нийт орлогын 20%-ийг бүрдүүлж байна.

### **Хөгжингүй болон хөгжиж буй улсуудын үнийн зохицуулалтын бодлого**

Улс орнуудын үнэ зохицуулах бодлого нь харилцан адилгүй байдаг бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд ялгаатай байдал ажиглагддаг.

Хөгжингүй орнуудын хувьд дотоодын үнийг дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр барих бодлого баримтлан дотоодын ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчид

нэмэлт зардал ноогдуулах замаар үйлдвэрлэгчдийг дэмждэг. ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын хэрэглэгчид ногдох нэмэлт зардал нь үнийн дүнгийн 10%-аас илүү байгаа бол Исланд, Өмнөд Солонгос, Япон, Норвег улсуудад хэрэглэгчид ногдох нэмэлт зардал үнийн дүнгийн 35%-аас их байна. ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр дэлхийн зах зээлийн үнэ болон үйлдвэрлэгчийн борлуулалтын бодит үнийн зөрүү нь Исландад 94%, Норвегт 75%, Өмнөд Солонгост 68%, Японд 61% байна.

Харин хөгжиж буй орнуудын хувьд дотоодын хүнсний бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дотоодын үнийг экспортын үнээс бага байлгах бодлого баримтлах нь түгээмэл байдаг. ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр 2018-2020 оны хооронд жилд дунджаар 104 тэрбум ам.долларын сөрөг Market Price Support буюу дотоодын үнийг бууруулах нөлөө бий болгосон байна. Бразил, Аргентин, Казахстан, Вьетнам, Энэтхэгт хэрэглэгчид ХАА-н бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээс бага үнээр хэрэглэж байна. Дэлхийн зах зээлийн үнэ болон үйлдвэрлэгчийн борлуулалтын бодит үнийн зөрүү нь Энэтхэгт 14%, Аргентинд 20%, Вьетнамд 10%, Казахстанд 3% орчим байна.

### **ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага**

Зах зээлийн зохицуулалт, үнийн зохицуулалтын арга хэмжээ авах бодлого нь дотоодын хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх боловч дэлхийн хэмжээний хүнсний хомстолд хүргэх сөрөг нөлөөтэй. Үнийг өндөр түвшинд барьснаар дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулж, хэрэглэгчдэд нэмэлт дарамт болдог гэж үздэг. Тиймээс зах зээлийн зохицуулалт, үнийн зохицуулалтын арга хэмжээнд шүүмжлэлтэй хандаж байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнууд зах зээлд нөлөөлөх, үнийн зохицуулалтын дэмжлэгийн бодлогын арга хэмжээгээ багасгах болсон. 2015 онд батлагдсан Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрмээр экспортыг дэмжсэн татаасыг хориглосноор ихэнх улсууд үнийн зохицуулалтын бодлогоосоо татгалзах болсон байна. Оронд нь орлого дэмжих төсвийн татаасын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Жишээ нь: Швейцар үнийн зохицуулалтын дэмжлэгээ бууруулж фермерүүдэд олгодог шууд татаасын хэмжээг нэмэгдүүлсэн. Гэхдээ энэхүү татаас нь байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжих нөхцөлд олгогддог. Швейцарын төсвийн татаас нь 1980 онд үйлдвэрлэгчид олгодог дэмжлэгийн 20% байсан бол 2020 оны байдлаар 50%-д хүрээд байна. Хөгжингүй орнуудын ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага нь дараах хэлбэртэй байна.

- Үнийн зохицуулалт гэх мэт зах зээлд нөлөөлөх бодлогоос татгалзах;
- Чөлөөт худалдааг дэмжих;
- Дэд бүтэц, судалгаа шинжилгээнд хөрөнгө оруулах;
- Шинэ технологи нэвтрүүлэн ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Байгаль орчинд ээлтэй ХАА-г дэмжих, ногоон технологи нэвтрүүлэх.

## **ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

### **1.КАНАД УЛС**

Канад Улсад 1951 онд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Зөвлөлийн тухай хууль (Agriculture Product Board Act) батлагдсанаар ХАА-н бүтээгдэхүүний үнийг зохицуулж эхэлсэн түүхтэй. (Энэ хууль 1997 онд Agricultural Marketing Programs Act батлагдсанаар хүчингүй болсон) Анхандаа Canada Wheat Board буюу Канадын Улаан буудайн зөвлөлөөр дамжуулан үр тарианы зах зээлд зохицуулалт хийж эхэлсэн байна. 1958 онд Хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангах тухай хуулийг (Agriculture Stabilization Act) баталснаар 9 төрлийн бүтээгдэхүүнд зах зээлийн зохицуулалт (үнийн зохицуулалт) хийж байсан.



Түүнчлэн Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль (Canadian Dairy Commission Act) батлагдснаар сүү, сүүн бүтээгдэхүүнд үнийн зохицуулалт, нийлүүлэлтийн хязгаарлалтын арга хэмжээг авах талаарх зах зээлийн зохицуулалтыг хуульчилсан байна. Канадын ХАА-г дэмжих бодлогыг 3 үед хувааж үздэг. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Канадын ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага

Үе	Бодлогын чиг хандлага	Бодлогын арга хэмжээнүүд
1985 оноос өмнөх	Импортын протекционизм, экспортын дэмжлэг, дотоод зах зээлийн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Импортын ижил төрлийн бүтээгдэхүүнд өндөр татвар ногдуулах</li> <li>Импортын квот тогтоох, импортын тарифын квотыг тогтоох</li> <li>Экспортын бүтээгдэхүүнд татаас олгох</li> <li>ХАА-н бүтээгдэхүүний тээврийн зардалд татаас олгох</li> <li>Үр тариа, сүү, сүүн бүтээгдэхүүн, шувууны мах, махан бүтээгдэхүүнд нийлүүлэлтийн зохицуулалт (үнийн зохицуулалт) хийх</li> <li>Marketing Board буюу Маркетингийн зөвлөлөөр дамжуулан үнийн хяналт тогтоох (Канадын Улаан Буудайн зөвлөл гэх мэт)</li> </ul>
1985-2000 он	Бодлогын шинэчлэлийг аажмаар тууштай хэрэгжүүлэн чөлөөт худалдааг дэмжиж эхэлсэн. Орлого болон борлуулалтыг дэмжихэд илүү чиглэгдэх болсон.	<ul style="list-style-type: none"> <li>ХАА-н бүтээгдэхүүний импортын татварыг бууруулж квотын арга хэмжээг багасгах</li> <li>Нийлүүлэлтийн зохицуулалт болон үнийн хяналтыг багасгах (Маркетингийн зөвлөлийн үр нөлөө буурсан)</li> <li>Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан</li> <li>Баруун бүсийн үр тарианы тогтворжуулалтын хөтөлбөрийг зогсоох</li> <li>Фермерүүдэд татаас (орлогын тогтвортой байдлыг хангах) олгох</li> <li>Даатгалын татаасыг нэвтрүүлэх</li> </ul>
2000 оноос хойш	Орлогын тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн Холбооны Засгийн газар болон муж улсуудын хамтын ажиллагааг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх болсон.	<ul style="list-style-type: none"> <li>Сүү, сүүн бүтээгдэхүүн, шувууны мах, махан бүтээгдэхүүн болон өндөг зэрэг бүтээгдэхүүнд үнэ тогтоох, импортын тариф, үйлдвэрлэлийн хэмжээний хяналт тогтоох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн нийлүүлэлтийн зохицуулалтыг үргэлжлүүлж байна.</li> <li>ХАА-н бодлогыг Холбооны Засгийн газар болон муж улсууд хамтран боловсруулах болсон.</li> <li>Фермерүүдийн орлогын тогтвортой байдлыг хангахад зориулсан татаасын бодлого хэрэгжүүлдэг.</li> <li>Фермерүүдийг хуримтлал үүсгэхийг дэмжсэн татаасын бодлогыг хэрэгжүүлдэг.</li> <li>Даатгалын татаасын бодлого хэрэгжүүлдэг.</li> </ul>

Канадын ХАА-н бодлогын түүхээс харахад үйлдвэрлэгчдэд давуу байдал олгосон зах зээлийн зохицуулалтын арга хэмжээгээ багасгаж оронд нь ХАА-н өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, фермерүүдийн орлогын тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн бодлого хэрэгжүүлэх болсон байна. ХАА-н салбарт үзүүлэх дэмжлэгийн хэмжээ нь 1980-аад оны дунд үед ДНБ-ний 1.6%-ийг эзэлж байсан бол 2020 оны байдлаар 0.3% болж буурсан байна. Үйлдвэрлэгчдэд үзүүлэх дэмжлэг нь мөн буурсаар ирсэн бөгөөд 1985 онд фермерүүдийн орлогын 35%-ийг үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг бүрдүүлж байсан бол одоогийн байдлаар 9% болж буурсан байна. Энэ нь ЭЗХАХБ-ын дунджаас 2 дахин бага үзүүлэлт юм.

### Үнэ зохицуулах бодлого

Канадын үнэ зохицуулах бодлогыг Supply management буюу Нийлүүлэлтийн зохицуулалт гэж нэрлэдэг. 1960-аад онд технологийн дэвшлийн үр дүнд Канадад ХАА-н үйлдвэрлэлийн илүүдэл бий болж эхэлсэн. Энэ үед фермерүүд, Холбооны засгийн газар, муж улсын засгийн газарт шаардлага тавин Маркетингийн зөвлөл (Marketing board) байгуулан зах зээл дэх

нийлүүлэлт, үнэд нөлөөлөх зорилгоор Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх болсон.

Одоогийн байдлаар нийлүүлэлтийн зохицуулалтад 5 төрлийн бүтээгдэхүүнийг хамруулж байна.

- Сүү, сүүн бүтээгдэхүүн;
- Тахианы мах, махан бүтээгдэхүүн;
- Цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн;
- Өндөг;
- Үржүүлгийн өндөг.

Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогоор 3 арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

1. Үйлдвэрлэлийн хэмжээний хяналт;
2. Үнэ тогтоох механизм;
3. Импортын хяналт.

Үйлдвэрлэлийн хэмжээний хяналт. Энэ нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн илүүдлээс шалтгаалан үнийн бууралт бий болохоос сэргийлж улсын хэмжээнд үйлдвэрлэлийн хэмжээг тогтоон, муж бүрт хуваарилах арга хэмжээ юм.

Үнэ тогтоох механизм. Энэ нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний хамгийн бага баталгаат үнийг фермерүүдэд зориулж тогтоох арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, фермерүүд Мужийн Маркетингийн зөвлөлөөр дамжуулан худалдан авагчтай зөвшилцөн тухайн ХАА-н бүтээгдэхүүний өртөгт суурилсан худалдах үнийг тогтоодог.

Импортын хяналт. Дотоодын үйлдвэрлэлд хэмжээ, үнийн зохицуулалт хийхээс гадна дотоодын зах зээлийг хамгаалах зорилгоор тухайн ХАА-н бүтээгдэхүүний импортод татварын болон квотын хязгаарлалт тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

1966 онд Канадын Сүү, сүүн бүтээгдэхүүний Комисс, 1972 онд өндөгний Маркетингийн Зөвлөл, 1974 цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүний Маркетингийн Зөвлөл, 1978 онд тахианы мах, махан бүтээгдэхүүний Маркетингийн Зөвлөл тус тус байгуулагдаж Нийлүүлэлтийн зохицуулалтыг хийх болсон.

2020 оны байдлаар дотоодын үйлдвэрлэгчдэд 4.8 тэрбум долларын дэмжлэг үзүүлсний 2.7 тэрбум буюу 60% нь үнийн зохицуулалтын дэмжлэг (нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээ) байна. Дэмжлэгийн нөлөө хамгийн өндөр бүтээгдэхүүн сүү, сүүн бүтээгдэхүүн бөгөөд фермерүүдийн тухайн бүтээгдэхүүнээс олох нийт борлуулалтын орлогын 34%-ийг бүрдүүлж байна. Шувууны мах, махан бүтээгдэхүүний дэмжлэг нь фермерүүдийн тухайн бүтээгдэхүүнээс олох нийт борлуулалтын орлогын ойролцоогоор 16%-ийг, өндөг ойролцоогоор 10%-ийг тус тус бүрдүүлж байна.

### **Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогын (Supply management) эрх зүйн орчин**

Канадын Үндсэн хуулиар ХАА-н салбарт бодлого хэрэгжүүлэх эрх мэдлийг Холбооны Засгийн газар болон мужийн Засгийн газрын аль аль нь эдлэх эрхтэй байхаар заажээ. Иймээс ХАА-н салбарын бодлогыг боловсруулахдаа Холбооны Засгийн газар болон Мужийн Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг баримталдаг. Холбооны улсын түвшний үйл ажиллагаа нь нийт улс даяар хэрэгжих бодлогыг боловсруулахад чиглэгддэг бол мужийн түвшинд тухайн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Канадын ХАА-н салбарт хэрэгжүүлж буй Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг дараах эрх зүйн актуудаар зохицуулж байна.

- Холбооны улсын хууль, эрх зүйн акт;

- Мужийн хууль, эрх зүйн акт;
- Холбооны улсын Засгийн газрын шийдвэр;
- Мужийн Засгийн газрын шийдвэр;
- Үндэсний ХАА-н бүтээгдэхүүний зөвлөлийн шийдвэр;
- Холбооны улсын түвшний Маркетингийн зөвлөлийн шийдвэр;
- Мужийн Маркетингийн Зөвлөлийн шийдвэр.

1967 онд батлагдсан Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль (Canadian Dairy Commission Act)<sup>135</sup> нь тухайн бүтээгдэхүүнтэй холбогдох харилцааг зохицуулдаг бол 1972 онд батлагдсан Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хууль (Farm Products Agencies Act) болон түүнд нийцүүлэн гаргасан мужийн хуулиуд Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг зохицуулдаг гол эрх зүйн акт болно.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хуульд (Farm Products Agencies Act)<sup>136</sup> нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих эрх, үүрэг бүхий Холбооны улсын түвшний агентлаг (ерөнхийд нь Маркетингийн зөвлөл гэж нэрлэдэг) байгуулах, түүний бүтэц, эрх мэдэл, үүргийн талаар зохицуулсан байна.

Мужууд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хуульд (Farm Products Agencies Act) нийцүүлэн өөрсдийн мужийн хүрээнд мөрдөгдөх хуулийг батлан Мужийн Маркетингийн Зөвлөл (Provincial Marketing Board) байгуулж, эрх үүргийг нь зохицуулдаг байна.

Канадад Нийлүүлэлтийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг эрх бүхий 3 бүтэц байдаг.

1. National Farm Products Council буюу Үндэсний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зөвлөл;
2. Farm Product Marketing Agency буюу Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороо;
3. Provincial Marketing Board буюу Мужийн Маркетингийн зөвлөл.

#### National Farm Products Council буюу Үндэсний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зөвлөл

Зөвлөл нь Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлого, арга хэмжээнд хяналт тавих хяналтын функц бүхий бүтэц бөгөөд дараах үндсэн чиг үүрэгтэй байна.

- ХАА-н бүтээгдэхүүний Маркетингийн хороог байгуулах үйл явцад хяналт тавих;
- ХАА-н бүтээгдэхүүний Маркетингийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих.

Энэхүү Зөвлөлийг байгуулах, гишүүдийг томилох эрхийг Канадын Амбан захирагч эдэлнэ.

Зөвлөл нь 3-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дор хаяж 50% нь үйлдвэрлэгчдийн төлөөлөл байна. Бүрэлдэхүүнийг сонгохдоо Канадын Баруун бүс, Төвийн бүс, Атлантын бүсийн төлөөллийг тэнцүү хэмжээтэй байлгах зарчмыг баримтална.

#### Farm Product Marketing Agency буюу Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороо

Хороо нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг боловсруулж, арга хэмжээг тодорхойлдог үндсэн бүтэц юм.

Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч-фермерүүдийн гаргасан хүсэлт болон тэдгээрийн дунд явуулсан санал асуулгыг үндэслэн Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороог байгуулах тухай шийдвэрийг Канадын Амбан захирагч гаргана.

<sup>135</sup> Canadian Dairy Commission Act, [https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u\\_3ilbnioCM4H4s-2OVmwyEuaP54L-YH\\_Wx9zeSr4Lm19dfw](https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u_3ilbnioCM4H4s-2OVmwyEuaP54L-YH_Wx9zeSr4Lm19dfw)

<sup>136</sup> Farm Products Agencies Act, <https://lois-laws.justice.gc.ca/eng/acts/F-4/page-1.html?fbclid=IwAR2WSFIS71MGlU3PULkaJ5qzmSK691vwOjvz8WAnQgXEIRtD2aVMm8FUql#docCont>

Энэхүү Хороог шаардлагатай гэж үзсэн ХАА-н аль ч бүтээгдэхүүний хувьд байгуулж болдог. Гэхдээ одоогоор тамхи, өндөг, шувууны махнаас бусад бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэлийн хэмжээний хязгаарлалт тогтоодоггүй байна.

Хорооны үндсэн чиг үүрэг:

- Нийлүүлэлтийн зохицуулалт бүхий ХАА-н бүтээгдэхүүний салбарын бодлогыг тодорхойлох;
- Муж хоорондын ХАА-н бүтээгдэхүүний худалдааг зохицуулах;
- Тухайн бүтээгдэхүүний экспортын бодлогыг тодорхойлох;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг муж бүрээр тогтоох;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдах, хадгалах, тээвэрлэх, даатгах, экспортлох;
- Үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

#### Provincial Marketing Board буюу Мужийн Маркетингийн зөвлөл

Мужийн Маркетингийн зөвлөл нь Нийлүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлдэг гол бүтэц бөгөөд түүний үйл ажиллагаа тухайн муж улсын хуулиар зохицуулагдана. Энэхүү Зөвлөлийн бүрэлдэхүүнийг гишүүн фермерүүдийн сонгуулиар бүрдүүлдэг.

Мужийн Маркетингийн зөвлөлийн үндсэн чиг үүрэг:


- Мужийн түвшинд тухайн ХАА-н бүтээгдэхүүний талаарх бодлогыг Холбооны улсын түвшний бодлоготой уялдуулан тодорхойлох;
- Тухайн мужид ноогдсон үйлдвэрлэлийн квотыг гишүүн фермерүүдэд хуваарилах;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүний худалдах үнийг тогтоох;
- Мужийн түвшинд тухайн ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдах, хадгалах, тээвэрлэх, даатгах, экспортлох;
- Үйлдвэрлэгч, фермерүүдийн эрх ашгийг хамгаалсан бодлого хэрэгжүүлэх.

## **2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

БНСУ нь 2020 оны байдлаар дэлхийд 10-т орох том эдийн засагтай улс бөгөөд ДНБ нь 1.6 их наяд ам.доллар-т хүрч, нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 31,755 ам.доллартай тэнцэж байна. БНСУ-ын иргэдийн 90 гаруй хувь нь томоохон хотуудад амьдардаг ба хүнсний хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрлэл нь хангадаг. АНУ 2020 оны байдлаар тус улсад 8.8 тэрбум ам.долларын ХАА-н бүтээгдэхүүн экспортолсон нь АНУ-ын экспортын тав дахь том зах зээл юм.<sup>137</sup>

**БНСУ-ын хэрэглэгчдэд чиглэсэн импортын бүтээгдэхүүн:** БНСУ 2020 онд 14.8 тэрбум ам.долларын хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүн импортолсон нь ХАА-н импортын 41 хувийг эзэлж байна. Хэрэглэгчдэд чиглэсэн ХАА-н хүнсний гол бүтээгдэхүүнд үхрийн мах, гахайн мах, жимс жимсгэнэ, модны самар, сүүн бүтээгдэхүүн, чихэр, ундаа, цаашлаад бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүнүүд багтдаг байна.

Зураг 2. БНСУ-д хэрэглэгчдэд чиглэсэн ХАА-н хүнсний бүтээгдэхүүн импортолж буй голлох улсууд




<sup>137</sup> Exporter Guide, Sanqvoq OhOctober 14, 2021

**Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрүүд:** Тус улс 2020 оны байдлаар 30,000 гаруй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компанитай болж, 56 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн байна. БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд нь импортын бүтээгдэхүүн, орц найрлага түүхий эдээс ихээхэн хамаардаг байна. ХАА-н үндсэн болон завсрын бүтээгдэхүүний импорт 2020 онд 13.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Эдгээр импортын бүтээгдэхүүний 23% буюу 3.1 тэрбум ам.долларыг АНУ-аас импортолсон байна.

**Хүнсний жижиглэнгийн худалдаа:** БНСУ-ын хүнсний жижиглэнгийн борлуулалт 2020 онд нийт 103 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт жижиглэнгийн худалдааны 29%-ийг эзэлж байна. Хүнсний супермаркетууд нь хүнсний жижиглэнгийн худалдааны тэргүүлэгч борлуулагчид бөгөөд дараа нь онлайн жижиглэн худалдаачид, том хэмжээний хайпармаркетууд, энгийн дэлгүүрүүд, их дэлгүүрүүд ордог байна. Ирэх 5-10 жилийн хугацаанд онлайн жижиглэнгийн худалдаачид болон дэлгүүрүүд бусад сувгуудаас илүү хурдан өсөх төлөвтэй байна. Онлайн худалдаачдын хурдацтай өргөжиж байгаа нь ердийн жижиглэнгийн худалдааны сувгуудын орон зайн бүтцийг өөрчлөх, хэрэглэгчдийн урсгалыг татах шинэ стратеги боловсруулахад хүргэж байна.

**Экспортын хүнсний бүтээгдэхүүн:** БНСУ-ын Гаалийн албаны статистик мэдээгээр, тус улсын хүнсний бүтээгдэхүүний экспорт 2020 онд 4.3 тэрбум ам.долларын тээвэрлэлт хийсэн байна. БНСУ-ын нийт экспортын барааны хэмжээ буурсан хэдий ч хүнсний экспортын хэмжээ (14.6%) түүхэндээ байгаагүй хамгийн өндөр өсөлтөд хүрсэн байна. Тодруулбал, цагаан будааны бүтээгдэхүүн 53.3%-аар өсч 37 сая ам.доллар, рамен (бэлэн хоол) 29.9%-аар өсч 604 сая ам.долларт хүрчээ. БНСУ 1960-аад оноос далайн гаралтай бүтээгдэхүүн, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн байна. 1988 оны Сөүлийн олимп, 2002 оны хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дараа БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүнүүд бусад улс руу экспортлох хэмжээ, чанарыг нэмэгдүүлсэн ба дэлхий даяар кимчи, рамен, архины эрэлтийг бий болгосон. 2019 онд хүнсний бүтээгдэхүүний экспорт БНСУ-ын нийт экспортын ердөө 1.2%-ийг л эзэлж байгаа нь дунджаар 7.7%-ийн хүнсний бүтээгдэхүүн экспортолдог бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүний экспорт тогтмол нэмэгдсээр байна.<sup>138</sup>

*Зураг 3. 2012-2020 оны хооронд БНСУ-аас экспортолсон хүнсний үнэ (тэрбум доллараар)<sup>139</sup>*



<sup>138</sup> Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>

<sup>139</sup> <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>

2020 онд хүнсний экспортын үнэ 7,98 тэрбум ам.доллар болж, өмнөх оны үзүүлэлтээс ойролцоогоор 0.31 тэрбум ам.доллараар өссөн байна. Экспортын хэмжээ 2012 оноос жил бүр тогтвортой өссөөр байна.

Ковид-19 Цар тахлын үед БНСУ-ын хүнсний экспорт тасралтгүй өссөн ба тэр дундаа кимчи, рамен (бэлэн хоол)-ы экспортын хэмжээ онцгой өссөн байна. Солонгос Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2020 онд 01 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд ХАА хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээ 4.9%-аар өссөн (4.9 сая ам доллар) хэмээн зарласан ба тэр дундаа кимчиний экспортын хэмжээ хамгийн их буюу 40.3% (97.9 сая ам доллар) ба түүний дараа рамен 36.7% (89.1 сая ам доллар) тус тус өссөн байна.

Олон улсын худалдааны нэгдсэн сан бүхий ОЕС-д тавигдсан мэдээллээр 2020 оны байдлаар БНСУ-ын ургамлын гаралтай, амьтны гаралтай хүнсний 189 нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн байна. Үүнээс 10 топ бүтээгдэхүүний төрөл нь дараах байдлаар бүртгэгдсэн байна.<sup>140</sup>

*Хүснэгт 3.БНСУ-ын ургамлын болон амьтны гаралтай хүнсний топ 10 бүтээгдэхүүн*

Төрөл	Бүтээгдэхүүн	Худалдааны үнэ
Хүнс	Ороосон тамхи /Rolled Tobacco/	893.820.950\$
Хүнс	Боловсруулсан жимс болон самар /Other Processed Fruits and Nuts/	814.955.669\$
Хүнс	Паста /Pasta/	784.298.722\$
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	Хөлдөөсөн загас /Non-fillet Frozen Fish/	607.331.873\$
Хүнс	Бусад хүнсний бэлдмэл /Other Edible Preparations/	604.196.706\$
Хүнс	Амттай ус /Flavored Water/	498.684.457\$
Хүнс	Соус ба амтлагч /Sauces and Seasonings/	309.068.965\$
Хүнс	Гурилан бүтээгдэхүүн /Baked Goods/	281.399.472\$
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	Загасны мах /Fish Fillets/	26.307.8471\$
Хүнс	Боловсруулсан хавч /Processed Crustaceans/	25.789.7192\$

**Төрөөс баримталж буй бодлого, хууль эрх зүйн орчин**

Цагаан будааны тариалан эрхлэгчид цагаан будааны орлогын нөхөн олговрын тухай хуулийн (Rice Income Compensation Act<sup>141</sup>) дагуу төрөөс дэмжлэг авдаг байна. Үүнд,

Талбайн төлбөр: Энэхүү төлбөрийг “га тутамд” тооцож, 1998-2000 оны суурь үеийн цагаан будааны үйлдвэрлэлийн дундаж талбайг ашиглан тооцдог. 2018 оны талбайн дундаж төлбөр нэг га талбайд дунджаар 909 ам. доллар байна.

Энэхүү дэмжлэгийн хөтөлбөрт хамрагдсан талбай 2018 онд 818,000 га талбайд хүрсэн бөгөөд газар ашигласны төлбөр 817.1 тэрбум солонгос вон (743 сая доллар) болсон байна.

Ургацын хомстлын төлбөр (Deficiency Payment): 2018 оны ургац хураалтын үеийн улсын дундаж зах зээлийн үнэ болон Засгийн газраас тогтоосон 2018 оны зорилтот үнийн зөрүүнээс талбайн төлбөрийг хасч тооцсон үнийн дүнгийн 85 хувиар хомстлын төлбөр төлнө.

Дээрх хоёр төрлийн төлбөрөөс цагаан будааны тариалан эрхлэгчдийг төрөөс дэмжин хөнгөлөлт үзүүлдэг байна.

<sup>140</sup> [https://oec.world/en/visualize/tree\\_map/hs92/export/kor/all/show/2020/](https://oec.world/en/visualize/tree_map/hs92/export/kor/all/show/2020/)

<sup>141</sup> <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=Rice+Income+Compensation+Act+&x=0&y=0#lBgcolor0>

Нийтийн хүнсний үр тарианы нөөцийг хангах Засгийн газрын будаа худалдан авах хөтөлбөр (Government Rice Purchase Program under the Public Food Grain Stockholding Program): Засгийн газар хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс нийгэмд шаардлагатай будааны нөөцийг бүрдүүлэх зорилгоор будааг худалдаж авдаг. Уг хөтөлбөрийн дагуу БНСУ-ын засгийн газар ургац хураалтын үеэр дотоодын цагаан будааг зах зээлийн дундаж үнээр худалдаж аван дараа нь ургац хураалтын бус үед дотоодын зах зээлийн үнээр борлуулдаг. 2018 оны 10-р сараас 12-р сарын хооронд БНСУ-ын засгийн газар 340,000 тонн энгийн будаа 350,000 МТ (тээрэмдсэн) цагаан будаа, нөөцөд зориулан нэмэлтээр 10,000 тонн будаа худалдаж авсан байна.

Засгийн газар болон Үндэсний Хөдөө Аж Ахуйн Хоршоодын Холбооны (NACF) цагаан будааны бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хөтөлбөрүүд (Government and National Agricultural Cooperative Federation's (NACF's) Loan Programs to Rice Millers): Засгийн газар 2018 онд дээрх холбооны дэмжлэгтэйгээр дотоодын будаа үйлдвэрлэгчдэд 1.28 их наяд солонгос вон (1.16 тэрбум ам.доллар) жилийн 0-2 хувийн хүүтэй тусгай зээл олгосон байна. Мөн цаашлаад үндэсний тариаланчдын холбоо мөн цагаан будааны тариаланч тээрэмчдэд тэг хүүтэй 1.9 их наяд солонгос воны (1.7 тэрбум ам.доллар) зээлийг үргэлжлүүлэн олгосон. Уг зээлийн хөтөлбөрүүдийн гол зорилго нь дотоодын будаа үйлдвэрлэлтийг дэмжиж зах зээл дээрх үнийн дарамтыг бууруулах ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг байна.

Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах тухай хууль<sup>142</sup> (Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products): Уг хууль нь 5 бүлэг 57 зүйлтэй ба үүнд Ерөнхий заалтууд, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлтийн хяналт, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний зах зээл, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагуудын зохицуулалт, нэмэлт зохицуулалтууд зэрэг агуулгууд багтсан байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2021 оны 511 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон байна.

ХАА-н бүтээгдэхүүн, түүний дотор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ойн гаралтай бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг сайжруулах зорилгоор Засгийн газраас Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах санг (Price Stabilization Fund) байгуулсан байна. Тус сан нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

- Засгийн газрын хөрөнгө оруулалт;
- Сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Бусад сангаас оруулсан хөрөнгө оруулалт.

Уг сан ХАА-н бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах зорилгоор дараах төслүүдийг санхүүжүүлж, зээл олгодог байна.

- ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, үйлдвэрлэх, зах зээлд гаргахыг дэмжих төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүний борлуулалтыг сайжруулах төслүүд.

Уг хуулийн хүрээнд ХАА-н үйлдвэрлэл, дотоодын хэрэгцээг урт хугацаандаа тогтвортой хангах, хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах зэрэг холбогдох төслүүдэд зээл олгож санхүүжүүлэх хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг байна.

<sup>142</sup> Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%86%8D%EC%88%98%EC%82%B0%EB%AC%BC%EC%9C%A0%ED%86%B5%EB%B0%8F%EA%B0%80%EA%B2%A9%EC%95%88%EC%A0%95%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0%EC%8B%9C%ED%96%89%EA%B7%9C%EC%B9%99>



### БНСУ-ын үнэ зохицуулах бодлого

Зах зээлийн үнийг дэмжих тал дээр БНСУ дотоодын үнэ тогтворжуулах арга хэмжээнүүд, тухайлбал, Засгийн газрын хамтарсан худалдан авалт, квот, импортын хяналт зэрэг арга хэмжээнүүд багтдаг. 1994 оноос эхлэн цагаан будааны импортыг тусгай зөвшөөрлийн системээр хянадаг байсан нь үр дүнтэй арга хэмжээ болж байсан байна.

1993 он хүртэл Засгийн газар цагаан будааны нөөцийг бүрдүүлж худалдан авалт хийн жижиглэнгийн тогтмол үнээр зарж байсан ба одоо хувийн хэвшлийн сувгууд зах зээлд цагаан будаа нийлүүлж байна. Одоогоор импортын бүтээгдэхүүнд зөвхөн тариф ногдуулдаг болсон.

Цагаан будаа: ХАА-н үйлдвэрлэлийн нийт үнийн дүнгийн 30 гаруй хувийг цагаан будаа дангаараа эзэлдэг ба ХАА-н голлох чухал бүтээгдэхүүн юм. Цагаан будааны салбарын бодлого нь дотоодын үнийг дэмжих зорилготой хэд хэдэн оролцогч талуудаас бүрддэг бөгөөд үүнд Засгийн газар дотоодын үйлдвэрлэлийг зохицуулалттай үнээр худалдан авах, импортыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүд орно. 1970-аад оноос хойш Засгийн газар цагаан будааны үйлдвэрлэлийн тодорхой хувийг худалдан авч, зах зээл дээр борлуулагдах үнэ болон худалдан авах хэмжээг урьдчилан тогтоодог байсан байна. 1980-аад оны үед Засгийн газрын худалдан авсан цагаан будааны зах зээлд эзлэх хувь 14-23%-д хэлбэлзэж байв. Энэ нь 1990 онд 29%-д хүрч, 1990-ээд оны эхээр бага зэрэг буурч, 1994-1996 онд 30% орчим болсон байна.

### 3.ЯПОН УЛС

Япон Улс 2020 оны байдлаар нийт экспортын хэмжээгээр дэлхийд 4-т, импортын хэмжээгээр 5-д, нэг хүнд ногдох ДНБ-ээр (одоогийн ам.доллар) 25-т жагссан үзүүлэлттэй байна.<sup>143</sup>

ОЕС-ийн тайланд<sup>144</sup> дурдсанаар, 2022 оны 3 дугаар сарын байдлаар тус улс нь 8.46 иений экспорт, 8.87 иений импорт хийж, худалдааны тэнцэл 414 тэрбум иен болжээ. 2021 оны 3 дугаар сараас 2022 оны 3 дугаар сарын хооронд экспорт 7.38 иенээс 8.46 иен хүрч 1.08 иенээр (14.7%), импорт 6.72 иенээс 8.87 иен хүрч 2.15 иенээр (32%) тус тус өссөн байна.

2020 онд Япон 64.7 сая долларын цагаан будаа экспортолж, дэлхийд 29-р байрт бичигдсэн байна. Японы цагаан будааны гол экспортлогч орнууд:

- Хонконг 28% (16.8 сая ам.доллар)
- Сингапур 12.4% (7.35 сая ам.доллар)
- Бусад Азийн орнууд 9.89% (5.83 сая ам.доллар)
- АНУ 8.98% (5.29 сая доллар)
- Мавритани 6.71% (3.95 сая доллар)
- Австрали 5.31% (3.13 сая доллар)
- Хятад 5.1% (3 сая ам.доллар)
- Тайланд 2.3% (1.36 сая ам.доллар)
- Их Британи 2.08% (1.23 сая ам.доллар)
- Сенегал 2.03% (1.2 сая ам.доллар)

**Экспортод гаргадаг хүнсний бүтээгдэхүүн.** Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспорт сүүлийн 6 жилийн хугацаанд тогтмол өссөн байна.<sup>145</sup> (Зураг 3)


<sup>143</sup> <https://oec.world/en/profile/country/jpn>

<sup>144</sup> <https://oec.world/en/profile/country/jpn>

<sup>145</sup> [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)




Зураг 4. Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон далайн гаралтай бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээ (тэрбум доллар), 2016-2021<sup>146</sup>



Source: Trade Data Monitor

Зураг 5. Японы хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, орноор (тэрбум доллар), 2016-2021<sup>147</sup>



Source: Trade Data Monitor

[https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20A%20ral%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20A%20ral%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)  
[https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20A%20ral%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20A%20ral%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)

Хүснэгт 4. Японы экспортод гаргадаг топ 20-н хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн  
(сая иен), 2016-2021<sup>148</sup>

Rank	Product	2016	2017	2018	2019	2020	2021	2021/16
1	Alcohol beverages	42,996	54,503	61,827	66,083	71,030	114,668	167%
2	Scallops	54,834	46,254	47,675	44,672	31,446	63,943	17%
3	Beef	13,552	19,156	24,731	29,675	28,874	53,679	296%
4	Sauces	27,372	29,590	32,539	33,657	36,542	43,533	59%
5	Soft drinks	19,431	24,505	28,167	30,391	34,164	40,570	109%
6	Yellow tail	13,473	15,380	15,765	22,920	17,262	24,620	83%
7	Confectionary/snacks	18,162	18,222	20,364	20,156	18,809	24,422	34%
8	Mackerel	17,986	21,885	26,690	20,612	20,444	22,025	22%
9	Logs	8,466	13,683	14,800	14,714	16,339	21,070	149%
10	Green tea	11,551	14,357	15,333	14,642	16,188	20,418	77%
11	Tuna and bonito	9,794	14,262	17,943	15,261	20,388	20,413	108%
12	Apples	13,299	10,948	13,970	14,492	10,702	16,212	22%
13	Sea cucumber	18,175	20,740	21,070	20,775	18,117	15,515	-15%
14	Tobacco	21,873	13,820	18,513	16,375	14,203	14,553	-33%
15	Infant formula	7,728	8,398	8,827	11,263	13,714	13,918	80%
16	Seeds for sowing	14,623	15,166	12,751	13,108	12,516	12,422	-15%
17	Soup broth	8,334	9,498	11,510	10,982	10,673	11,827	42%
18	Fish paste	9,272	9,520	10,667	11,168	10,382	11,258	21%
19	Instant coffee	2,419	2,363	2,792	3,493	9,231	8,822	265%
20	Bonsai trees	8,033	12,632	11,962	9,288	10,552	6,931	-14%

Source: MAFF

## ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Японы хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн экспортлохтой холбогдох харилцааг бие даасан хууль болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Үүнд:

- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах тухай хууль;
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль;
- Хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль.

**Хүнсний бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн үнийг тогтворжуулах тухай хууль** (Law for Stabilization of Supply Demand and Price of Staple Food)<sup>149</sup> –ийг баталж, 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Японы хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох цагаан будаа, улаан буудай, арвай нь ХАА-н салбарт чухал байр суурь эзэлдэг тул үйлдвэрлэгчдээс хэрэглэгчдэд цагаан будааг түгээх цогц арга хэмжээг авахаар тус хуульд тусгасан байна. Мөн Засгийн газраас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг худалдан авах, импортлох, борлуулах зэрэг арга хэмжээг энэхүү хуулиар зохицуулж байна.

<sup>148</sup> [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)

<sup>149</sup> Law For Stabilization Of Supply Demand And Price Of Staple Food, [https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh\\_9999-11.html](https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh_9999-11.html)

Хуулийн зорилго нь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, үнийг тогтворжуулах, улмаар иргэдийн амьдрал, үндэсний эдийн засгийг тогтвортой байлгахад хувь нэмэр оруулахад оршино.

Цагаан будааны эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах үндсэн чиглэлийг батлан эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулахын тулд Засгийн газар цагаан будааны эрэлт, нийлүүлэлтийн урьдчилсан тооцоог гаргадаг. Үүнд үндэслэн Засгийн газар цагаан будааны үйлдвэрлэлийн зохицуулалтыг жигдрүүлэх, нөөцийн урт, дунд хугацаанд үр ашигтай бодлого, дэмжлэг үзүүлэн ажилладаг.

**Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль** (Act on Facilitating the Export of Agricultural, Forestry, and Fishery Products and Food) –ийг 2019 онд баталсан.<sup>150</sup>

Хуулийн зорилго нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүн экспортлох төвийг байгуулах, дүрэм журмыг ханган ажиллах, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

Энэхүү хуулиар “Японы хүнсний бүтээгдэхүүнийг гадаадад сурталчилах төв”-ийн чиг үүргийг заасан байна. Японд үйлдвэрлэсэн хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор үндсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, экспортын гэрчилгээ олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Японы Засгийн газар хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж япон үндэсний хоол хүнсийг гадаадад сурталчлах болон бусад арга хэмжээг авч ажилласаар байна.

2017 онд Засгийн газрын харьяа Японы гадаад худалдааны байгууллагын дэргэд **Японы хүнсний бүтээгдэхүүнийг гадаадад сурталчлах төв**<sup>151</sup> (The Japan Food Product Overseas Promotion Center - JFOODO) байгуулагдаж Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний брэндийг сурталчлан ажиллаж байна. Иймд бүтээгдэхүүний экспортыг цаашид нэмэгдүүлэхийн тулд энэхүү хууль нь импортлогч орнуудтай Засгийн газрын хэлэлцээр хийх, экспортын гэрчилгээ олгох зэрэг экспорттой холбоотой тогтолцоог оновчтой болгох замаар экспортыг хөнгөвчлөх зорилготой юм.

**Японы хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль**<sup>152</sup> (Agricultural Export Facilitation Act)-ийг 2022 онд шинэчлэн баталжээ.

Хуулийн зорилго нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлтэд инновац хийхээр төлөвлөж буй хүнсний экспортын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгч, борлуулагчдад зээл авах эрх зүйн орчинг бүрдүүлжээ. Ингэснээр тухайн бүтээгдэхүүнд хамаарах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаатай зээлийн сан байгуулжээ. Тус хуулиар MFF-аас зөвшөөрөгдсөн хувийн хэвшлийн байгууллагуудад экспортын гэрчилгээ олгох тогтолцоог бий болгосон.

Мөн тус хуулиар дараах асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Онцлогтой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох;
- Зөвшөөрөгдсөн экспортлогчдод үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх;
- Хяналтын байгууллагаас экспортын гэрчилгээ олгох.

<sup>150</sup> Act on Facilitating the Export of Agricultural, Forestry and Fishery Products and Food, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3583/en>

<sup>151</sup> <https://www.jetro.go.jp/en/jfoodo/>

<sup>152</sup> [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)

Дээрх хууль эрх зүйн орчноос гадна дараах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

**Япон Улсын хөдөө аж ахуйн экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө**<sup>153</sup> Японы Засгийн газар Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүн тэдгээрийн экспортыг тэлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг 2020 онд баталсан.

Зорилго нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас, загасан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бөгөөд эдгээр салбарын бизнес эрхлэгчдийн ашгийг нэмэгдүүлэх юм. Мөн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг төвлөрүүлэх, бүс нутгуудыг тодорхойлж экспортод чиглэсэн бизнесийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж Засгийн газрын үйл ажиллагааг оновчтой болгох алхмуудыг хийх юм.

Экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө нь гурван үндсэн зарчим дээр суурилдаг.

- Японы давуу талыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох;
- Бүтээгдэхүүн экспортлох сорилтыг даван туулж буй бизнесүүдийг дэмжих;
- Экспортын саад бэрхшээлийг шийдвэрлэх засгийн газрын хандлагыг нэгтгэх.

Энэхүү стратеги төлөвлөгөөнд бүтээгдэхүүний экспортын зорилтыг 2025 онд хоёр их наяд иен (19 тэрбум ам.доллар), 2030 онд таван их наяд иен (48 тэрбум ам. доллар) болгох зорилттой экспортын өсөлтийг хангах боломжтой 27 бүтээгдэхүүнийг тодорхойлж, экспортыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Үхрийн мах
2. Гахайн мах
3. Тахианы мах
4. Өндөг
5. Хүүхдийн хуурай сүү
6. Алим
7. Усан үзэм
8. Тоор
9. Цитрус
10. Гүзээлзгэнэ
11. Амтат төмс
12. Цэцэг
13. Ногоон цай
14. Будаа (бэлэн бүтээгдэхүүн, нэг удаагийн хэрэглээний цагаан будааны гурил, цагаан будааны гурилан бүтээгдэхүүн)
15. Мод
16. Фанер
17. Бүри (шар сүүлт загас)
18. Тай (далайн боргоцой)
19. Хулуу
20. Судв
21. Ундаа
22. Чихэр
23. Соус, амтлагч
24. Мисо (шар буурцагны соус, нухаш)
25. Nihonshu (будааны дарс)
26. Виски
27. Шочу, Авамори (нэрмэл архи)

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>153</sup> [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy\\_Tokyo\\_Japan\\_12-10-2020](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy_Tokyo_Japan_12-10-2020)

Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн бодлогын чиг хандлага<sup>154</sup>

Хугацаа	Хэрэгжүүлсэн бодлого	Хөдөө аж ахуйн бодлогод гарсан өөрчлөлт
1960 оноос өмнө	Хөдөө орон нутгийн ядуурлыг арилгах, хүнсний хангамжийг нэмэгдүүлж	<ul style="list-style-type: none"> <li>Тариаланчдад тариалангийн талбай эзэмшихэд нь туслах зорилгоор газрын шинэчлэлийг хэрэгжүүлсэн;</li> <li>Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого (Хөдөө аж ахуйн хоршооллын тухай хууль 1947, Хөдөө аж ахуйн гамшгийн нөхөн төлбөрийн тухай хууль 1947, Хөдөө аж ахуйн газрын тухай хууль 1952;</li> <li>Хүнсний хомстлыг шийдвэрлэхийн тулд будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого (Хүнсний менежментийн тухай хууль 1942, Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 5 жилийн төлөвлөгөө 1952;</li> </ul>
1960-1980	Хөдөө аж ахуйн болон бусад салбаруудын орлогын ялгааг бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөө аж ахуйн хуулийн зорилго нь фермийн хэмжээг нэмэгдүүлэх, тариалангийн талбайг сайжруулах, хөдөө аж ахуйн техник технологийг нэвтрүүлэх, будаа улаан буудайн үйлдвэрлэлээс мал аж ахуй, хүнсний ногоо, жимс жимсгэнэ рүү шилжих замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх 1961 он;</li> <li>Цагаан будааны бодлогыг хэрэгжүүлсэн 1967 он;</li> <li>Цагаан будааны үйлдвэрлэлийн тохируулгын хяналтыг нэвтрүүлсэн 1971 он;</li> </ul>
1980-2010	Олон улсын түвшинд нийцүүлэх, хөдөө аж ахуйн салбарт зах зээлийн зарчмуудыг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн бодлогод “хөдөө орон нутаг”, “хүнс” гэсэн ойлголтуудыг нэгтгэх	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөө аж ахуйн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх тухай хуулиар мэргэшсэн тариаланчдад үзүүлэх дэмжлэгийг системчилсэн 1993 он;</li> <li>Үндсэн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, эрэлт, үнийг тогтворжуулах тухай хууль цагаан будааны улсын худалдаанд Засгийн газрын үүргийг өөрчилсөн 1994 он;</li> <li>Засгийн газар зөвхөн нөөцлөх зорилгоор худалдан авах;</li> <li>Цагаан будааны тоон квотыг тарифын квотоор сольсон 1999 он;</li> <li>Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн байдлын тухай хуулиар эдийн засаг, нийгмийн шинэ нөхцөлд хөдөө аж ахуйн тогтвортой бүтцийг бий болгох 1999 он;</li> <li>Алслагдсан газар тариалан эрхлэгчид хоол хүнсээр өөрийгөө хангах зорилт, шууд төлбөрийг нэвтрүүлсэн 1999 он;</li> </ul>
2010-одоог хүртэл	Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн шинэ шинэчлэл	<ul style="list-style-type: none"> <li>Тариалангийн газрын шинэчлэл (Хөдөө аж ахуйн газрыг нэгтгэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор 2009 оны Хөдөө аж ахуйн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2013 оны Хөдөө аж ахуйн газрын зуучлалын менежментийг дэмжих тухай хууль);</li> <li>Хөдөө аж ахуйн хоршоодын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015 он;</li> <li>Цагаан будааны үйлдвэрлэлийн квотын тогтолцоог халах 2018 он;</li> <li>Орлогын даатгалын хөтөлбөрийн танилцуулга 2019 он;</li> <li>Томоохон худалдааны хэлэлцээрүүд (Номхон далай дамнасан түншлэлийн иж бүрэн ба дэвшилтэт хэлэлцээр 2018 он, Япон-ЕХ-ны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр 2019, Япон-АНУ-ын худалдааны хэлэлцээр 2019, Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний экспортыг дэмжих хөтөлбөр.)</li> </ul>

#### 4.НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

Нидерланд нь 2020 оны байдлаар ДНБ-ээр дэлхийн хэмжээнд 17-р, эдийн засаг, нийт бүтээгдэхүүн экспортоор (511 тэрбум ам.доллар) 6-р, импортоор (524 тэрбум ам.доллар) 8-р, нэг хүнд ногдох ДНБ (экспорт 29.3 мянган ам.доллар, импорт 30.1 мянган ам.доллар)-

<sup>154</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/e4c38702-en/index.html?itemId=/content/component/e4c38702-en>

ээр 12-р байранд тус тус жагссан. Эдийн засгийн хүндрэлийн индексээр дэлхийн 127 улсаас 22-р байрыг эзэлсэн байна.<sup>155</sup>

*Хүснэгт 6. Нидерланд Улсын 2020 оны байдлаар экспорт, импортын үзүүлэлт (ам.доллараар)*

2020 оны нийт бүтээгдэхүүн		2020 оны нэг хүнд ногдох ДНБ		2018 оны худалдаа үйлчилгээ	
экспорт	импорт	экспорт	импорт	экспорт	импорт
511 тэрбум	524 тэрбум	29.3 мянга	30.1 мянга	253 тэрбум	239 тэрбум

Эх сурвалж: <https://oec.world/en/profile/country/nld>

*Хүснэгт 7. Нидерландын 2020 оны байдлаар экспорт, импортын бараа, бүтээгдэхүүн, (тэрбум ам.доллараар)*

Экспорт		Импорт	
Бусад амьд ургамал	4.4	Үйлдвэрлэлийн тосны хүчил, тос, спиртний төрөл	5.73
Тайрсан цэцэг	4.01	Какао, шошны төрөл	1.78
Соёолжны ханд	3.4	Тээврийн хэрэгсэл	1.55
Завь	2.81	Спиртний төрөл	1.25
Нүүрсний давирхайн тос	2.52	Хүнсний биш тос	1.14

Эх сурвалж: <https://oec.world/en/profile/country/nld>

2021 оны байдлаар:

2021 оны 10 дугаар сарын байдлаар Нидерланд Улс нь 45.1 тэрбум еврогийн бараа, бүтээгдэхүүнийг экспортолж, 43.1 тэрбум еврогийн бараа, бүтээгдэхүүнийг импортолсны үр дүнд 2.01 тэрбум еврогийн худалдааны тэнцэл эерэг гарсан байна.<sup>156</sup>

2020-2021 оны 10 дугаар сарын байдлаар:

- экспорт 41.5 тэрбум еврогоос 3.64 тэрбум еврогоор нэмэгдэж, 45.1 тэрбум евро буюу 8.76% -аар өссөн;
- импорт 35.3 тэрбум еврогоос 43.1 тэрбум европ хүрч, 7.8 тэрбум евро буюу 22%-аар тус тус өссөн үзүүлэлтэй байна.<sup>157</sup>

**Экспортод гаргадаг хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний жагсаалт, товч мэдээлэл**


АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны Хөдөө аж ахуйн гадаад харилцааны алба (United States Department of Agriculture, Foreign Agricultural service (USDA)) болон Дэлхийн хөдөө аж ахуйн мэдээллийн сүлжээний газар (Global Agricultural Information Network (GAIN))-ын хамтарсан “Хүнсний технологийн бүрэлдэхүүн” тайланг<sup>158</sup> 2022 оны 4 дүгээр сарын 04-ний байдлаар гаргажээ.

<sup>155</sup> <https://oec.world/en/profile/country/nld>

<sup>156</sup> <https://oec.world/en/profile/country/nld>

<sup>157</sup> <https://oec.world/en/profile/country/nld>

<sup>158</sup> Food Processing Ingredients, NL2022-001, 9April 04, 2022, [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients\\_The%20Hague\\_Netherlands\\_NL2022-0019.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf)



Source: Trade Data Monitor

2021 онд дараах 10 улс Нидерландад 1.5 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгч болсон байна. Үүнд, Герман, Испани, Итали, АНУ, Бельги, Англи, Бразил, Франц, Польш, Өмнөд Африк орно.

Уг тайланд дурдсанаар, Нидерландад 7340 гаруй хүнсний бүтээгдэхүүнийг компаниуд үйлдвэрлэсэн бөгөөд борлуулалтын цэвэр орлого нь 2021 онд 88 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь хүнсний жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 300,000 гаруй хүнийг

ажлын байраар тогтвортой хангасан, 4,300 гаруй хүнсний дэлгүүр үйл ажиллагаа эрхэлсэнтэй холбоотой аж. Мөн хүнсний бүтээгдэхүүний эргэлтийг хурдасгаж, онлайнаар бараа, бүтээгдэхүүнийг худалдаж авснаар 2020 онд 6.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх тайланд дурдсанаар, 2021 оны байдлаар хүнсний үйлдвэрлэл нь:

- хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүний импорт 50.6 тэрбум ам.доллар;
- хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүний экспорт 94.6 тэрбум ам.доллар;
- хөдөө аж ахуйн болон холбогдох бүтээгдэхүүний импорт 103.3 тэрбум ам.доллар;
- хөдөө аж ахуйн болон холбогдох бүтээгдэхүүний экспорт 140.9 тэрбум ам.доллар;
- хүнсний үйлдвэрлэл 88.0 тэрбум ам.доллар;
- хүнсний жижиглэнгийн үйлдвэрлэл 53.1 тэрбум ам.доллар;
- хүнсний үйлчилгээ 13.9 тэрбум ам.долларт хүрчээ.

Европын Холбоо (ЕХ)-ны хамгийн том импортлогч орон Нидерланд байдаг бөгөөд ХАА-н бүтээгдэхүүнээр АНУ болон Германы дараа ордог, экспортлогчоор дэлхийд хоёрдугаар байр эзэлдэг байна.<sup>159</sup>

### Ковид-19 цар тахлын үед

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Нидерландын хүнсний үйлдвэрлэгчдийн хувьд хүнд хэцүү үе байсан. Жил бүр гаргадаг “Хүнсний үйлдвэрлэлийн хяналт (Food Industry Monitor), Голландын Хүнс болон хүнсний аж үйлдвэрийн холбоо (Federation of Dutch Food and -FNLI)-той хамтарсан тайланд хүнсний үйлдвэрлэгчид ковидын үе ихээр нөлөөлсөн гэж мэдээлсэн. Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед Засгийн газар “Нийгмээс тусгаарлах арга хэмжээ” авсан нь хүнсний үйлдвэрлэлийн борлуулалт ойролцоогоор гуравны нэгээр буурсан гэж үзжээ. Энэ салбар хаагдсанаас болоод ундааны төрлийн үйлдвэрлэл, биеийн тамирын заал, усан бассейн болон бусад спорт, чөлөөт цагийг өнгөрөөх газар, хүнсний компаниудын бизнес зэрэг ихээхэн хохирол амссан байна. Хүнсний жижиглэнгийн худалдаачдын борлуулдаг хүнсний үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хувьд борлуулалт нэмэгдэж, супермаркетуудад илүү мөнгө зарцуулсан гэх мэдээлэл байна.

### Үнийн өсөлт

2021 оны сүүлийн хагас жилд хүнсний салбарынхан шинэ сорилт тулгарсан. ХАА-н түүхий эд, сав баглаа боодлын материал, ачаа тээвэр, эрчим хүч гээд янз бүрийн зардлуудад мэдэгдэхүйц өсөлт ажиглагдсан. Зарим түүхий эдийн үнэ 40 хүртэлх хувиар нэмэгдсэн, харин эрчим хүчний салбарын зардал 85%-аар өссөн үзүүлэлттэй байна. Сав, баглаа боодлын материал, тухайлбал цаас болон хуванцар зүйл нь ковидын өмнөх үеэс 6 болон 12 %-аар илүү үнэтэй болсон бөгөөд хүнсний түүхий эд худалдан авагч, далайн тээврийн үнийн өсөлттэй тулгарч байсан.

<sup>159</sup>[https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients\\_The%20Hague\\_Netherlands\\_NL2022-0019.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf)

Украины дайнтай холбоотойгоор сүлжээг тасалдах, зарим түүхий эдийн үнийн өсөлтөд нөлөөлсөн гэж үздэг. Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүнийг солих, дахин боловсруулах, туршилт хийх, бүтээгдэхүүний шошгыг өөрчлөх шаардлагатай болсон байна.

### **Хууль, эрх зүйн орчин**

Европын Парламент болон Зөвлөл 2019 оны 1381 тоот дүрэм (*Regulation 2019/1381 of the European Parliament and of the Council*) Хүнсний тухай хууль (Food law)-ийн ерөнхий зарчим, шаардлагыг тодорхойлсон.<sup>160</sup>

Европын Хүнсний аюулгүй байдлын агентлаг (European Food Safety Authority)-ыг байгуулж, хүнсний аюулгүй байдлын талаарх журмыг тогтоосон.

- Төрийн санхүүгийн тогтвортой байдлын тухай хууль (Sustainable Public Finances Act)
- Хууль тогтоомжид гарсан өөрчлөлтүүд Changes in law and regulations 1st Quarter 2022
- Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний импортын дүрэм болон стандарт (Food and Agricultural Import Regulations and Standards)
- Нидерландын Хүнсний Ерөнхий хуулийн зохицуулалт Regulation (EC) 178/2002 (General Food Law) ЕХ-ны Хүнсний хуулийн ерөнхий зарчим, шаардлагад нийцүүлсэн, уялдаа холбоотой зохицуулалт юм.

### **Төрийн байгууллага**

- Хүнсний аюулгүй байдал, эрүүл хүнсийг Эрүүл мэнд, халамж спортын яам (The Ministry of Health Welfare and Sport) хариуцдаг.
- Эрүүл мэнд, халамж, спортын яамны Хоол тэжээл, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх баг- Хүнсний аюулгүй байдал (Ministry of Health, Welfare and Sport Department for Nutrition, Health Protection and Prevention Team Food Safety)
- Хөдөө аж ахуй, байгаль, хүнсний чанарын яам (Ministry of Agriculture, Nature and Food Quality)
- Сангийн яам (Ministry of Finance)
- Нидерландын Хүнс, хэрэглээ, бүтээгдэхүүний аюулгүй байдлын газар (The Netherlands Food and Consumer Product Safety Authority - NVWA)

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>160</sup> <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32019R1381>



## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### КАНАД

- Canada's Supply Management System, Economics, Resources and International Affairs Division,  
[https://lop.parl.ca/sites/PublicWebsite/default/en\\_CA/ResearchPublications/201842E?fbclid=IwAR1TybruF30jD4l7PsbC\\_dfbqqMxxnSLhwZKrW0pr3X-T-DOG1HYIxxTERY#a3](https://lop.parl.ca/sites/PublicWebsite/default/en_CA/ResearchPublications/201842E?fbclid=IwAR1TybruF30jD4l7PsbC_dfbqqMxxnSLhwZKrW0pr3X-T-DOG1HYIxxTERY#a3)
- Agricultural Marketing Board,  
[https://www.thecanadianencyclopedia.ca/en/article/agricultural-marketing-board?fbclid=IwAR1VDbeic\\_\\_cOQ0uonRKbZENmaPIbJJSAT1TnhXW8X0cuDI-gKnyfpeWI](https://www.thecanadianencyclopedia.ca/en/article/agricultural-marketing-board?fbclid=IwAR1VDbeic__cOQ0uonRKbZENmaPIbJJSAT1TnhXW8X0cuDI-gKnyfpeWI)
- Agricultural Policy Monitoring and Evaluation 2021, OECD, 23 Jun 2022, <https://www.oecd-ilibrary.org/sites/1174c7b1-en/index.html?itemId=/content/component/1174c7b1-en>
- Canadian Dairy Commission Act, [https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u\\_3ilbnioCM4H4s-2OVMwyEuaP54L-YH\\_Wx9zeSr4Lm19dfw](https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u_3ilbnioCM4H4s-2OVMwyEuaP54L-YH_Wx9zeSr4Lm19dfw)
- Farm Products Agencies Act, <https://lois-laws.justice.gc.ca/eng/acts/F-4/page-1.html?fbclid=IwAR2WSFISS71MGlu3PULKaj5qzmSK691vwOjvz8WAnQgXEIRtD2aVMm8FUql#docCont>

### БНСУ

- The food and beverage Market entry handbook: South Korea
- Review of Agriculture policies in Korea
- Review of Rice: Production, Trade, Consumption, and Future Demand in Korea and Worldwide
- Rice Production Stays Steady Despite Government's Rice Reduction Program
- Exporter Guide, Sangyong Oh October 14, 2021
- Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>
- <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>
- [https://oec.world/en/visualize/tree\\_map/hs92/export/kor/all/show/2020/](https://oec.world/en/visualize/tree_map/hs92/export/kor/all/show/2020/)
- <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=Rice+Income+Compensation+Act+&x=0&y=0#liBgcolor0>

### ЯПОН

- <https://oec.world/en/profile/country/jpn>
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)
- Law For Stabilization Of Supply Demand And Price Of Staple Food-  
[https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh\\_9999-11.html](https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh_9999-11.html)
- Act on Facilitating the Export of Agricultural, Forestry and Fishery Products and Food-  
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3583/en>
- <https://www.jetro.go.jp/en/jfoodo/>
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act\\_Tokyo\\_Japan\\_JA2022-0030.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf)

- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy\\_Tokyo\\_Japan\\_12-10-2020](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy_Tokyo_Japan_12-10-2020)
- <https://www.oecd-ilibrary.org/sites/e4c38702-en/index.html?itemId=/content/component/e4c38702-en>

#### НИДЕРЛАНД

- <https://oec.world/en/profile/country/nld>
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients\\_The%20Hague\\_Netherlands\\_NL2022-0019.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf)
- <https://www.government.nl/topics/food/food-safety-requirements>
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma\\_2022\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf)
- <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2022/04/global-economic-outlook.pdf>
- [https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/WESP2022\\_CH2.pdf](https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/WESP2022_CH2.pdf)
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/short-term-outlook-spring-2022\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/short-term-outlook-spring-2022_en.pdf)
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/commodity-price-dashboard\\_2022-04\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/commodity-price-dashboard_2022-04_en.pdf)
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients\\_The%20Hague\\_Netherlands\\_NL2022-0019.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf)
- <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A02002R0178-20210526#M9-12>
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/2021-netherlands-stability-programme\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/2021-netherlands-stability-programme_en.pdf)
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma\\_2022\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf)
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients\\_The%20Hague\\_Netherlands\\_NL2022-0019.pdf](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf)
- [https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20and%20Agricultural%20Import%20Regulations%20and%20Standards%20Country%20Report\\_The%20Hague\\_Netherlands\\_12-31-2021](https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20and%20Agricultural%20Import%20Regulations%20and%20Standards%20Country%20Report_The%20Hague_Netherlands_12-31-2021)
- [https://atradiuscollections.com/documents/industry\\_trends\\_food\\_beverages\\_january\\_2022.pdf](https://atradiuscollections.com/documents/industry_trends_food_beverages_january_2022.pdf)
- [https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma\\_2022\\_en.pdf](https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf)
- <https://atradiuscollections.com/global/reports/food-industry-trends-netherlands-2022.html>
- [https://atradiuscollections.com/documents/industry\\_trends\\_food\\_beverages\\_january\\_2022.pdf](https://atradiuscollections.com/documents/industry_trends_food_beverages_january_2022.pdf)
- government-supported funding for agricultural products in the netherlands,2022 - Search (bing.com)
- English | Nationaal Groeifonds  
<https://wetten.overheid.nl/BWBR0001969/2018-11-17>
- Food safety requirements | Food | Government.nl  
<https://www.government.nl/binaries/government/documenten/policy-notes/2019/11/30/plan-of-action---supporting-transition-to-circular-agriculture/Plan+of+action+-+supporting+transition+to+circular+agriculture.pdf>

#### БУСАД

- Agricultural Policy Monitoring and Evaluation 2021,  
<https://www.oecd.org/publications/agricultural-policy-monitoring-and-evaluation-22217371.htm>